

8

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДЛУУД

Г.Баасанжав, Э.Эрдэнэтуяа

Удиртгал.

Монголын Төрийн аудитын байгууллага болон хувийн аудитын байгууллагууд нь үйл ажиллагаагаа өнөө үед Төрийн аудитын тухай хууль, Аудитын тухай хууль, Аудитын олон улсын стандарт, заавар журамд нийцүүлэхийн тулд аудитын ажилд чанарын хяналт тавьж, улмаар боловсронгуй болгох асуудал чухлаар тавигдаж байна. Тиймээс ч нягтлан бодогчид, санхүү бүртгэлийн мэргэжилтэн, санхүүгийн шинжээч, аудиторууд энэ салбарт чухал байр суурь эзлэн орчин үеийн нягтлан бодох бүртгэл аудитыг хөгжүүлэхэд нөлөөлж байна. Санхүүгийн тайланг баталгаажуулах эрсдлийг өөрсдөө үүрч хариуцлагаа ухамсарлаж аудитын шалгалтыг явуулж байгаа нь Аудитын олон улсын стандартад нийцэх алхамыг тавьж байна. Манай улсын хувьд нягтлан бодох бүртгэл, аудит, хөрөнгийн үнэлгээний асуудлыг зохицуулахад Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Олон улсын Санхүүгийн Корпораци, Жайка зэрэг олон улсын санхүүгийн байгууллагууд, донор орнуудын тусламж дэмжлэг их үүрэг гүйцэтгэж ирсэн.

Монгол улсын Аудитын тухай хууль, банк бус санхүүгийн байгууллагын тухай хуульд зааснаар хадгаламж зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоод болон, банк санхүү даатгалын байгууллагууд санхүүгийн тайлангаа жилд нэгээс доошгүй удаа аудитын байгууллагаар заавал баталгаажуулах шаардлагатай байдаг.

Ажил гүйлгээний онцлог, мөн үйл ажиллагааны цар хүрээнээс шалтгаалан богино хугацаанд эрсдэлд өртөх магадлал өндөр, нягтлан бодох бүртгэлийн зарчим, дотоод хяналт нь практик үйл ажиллагааны хөгжлөөс

хоцорч байгаагаас шалтгаалан санхүүгийн тайлангийн аудитыг тусгайлан авч үзэх шаардлага гарч ирсэн.

Нэг. Судлагдсан байдал.

1.1 Онол арга зүй-Аудитын чанарын хяналт.

Санхүүгийн тайлангийн аудитын зорилт нь санхүүгийн тайланг материаллаг бүх үзүүлэлтээр санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлж бэлтгэсэн эсэх талаар санал дүгнэлтээ илэрхийлэх боломжийг аудиторт олгоход оршино. Чанарын хяналтын олон улсын стандарт 1-д зааснаар аудитын үйлчилгээ үзүүлж буй тухайн пүүс, компани нь тухайн үйлчлүүлэгч байгууллагын аудитыг үр дүнтэй явуулсан эсэхэд анхаарч цаашид аудитын чанарт анхаарч ажиллахыг шаарддаг. Санхүүгийн тайлангийн аудит нь тухайн санхүүгийн тайлан үнэн зөв тайлагнагдсан эсэхэд мэдээлэл өгөх зорилгоор хийгддэг ажил үйлчилгээ юм. Тухайн ажил үйлчилгээг явуулахад Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон Аудитын олон улсын стандарт, Чанарын хяналтын олон улсын стандарт 1 баримтладаг бөгөөд энэ чиглэлээр аудиторын тайланг хүргүүлдэг. Аудитын олон улсын стандартаар санхүүгийн байгууллагын Санхүүгийн тайлангийн аудитад зайлшгүй шаардагдах тусгай материал нь удирдлагын талаарх баримт бичиг, дотоод хяналтын тогтолцоо, хяналт тайлангууд, зээлийн бүртгэлийн талаарх материал, цахим төлбөр тооцоо эрсдэл, санхүү тайлан дахь илчлэл, толилуулга гэх мэт зүйлүүд багтдаг. 2007 онд Чанарын хяналтын олон улсын стандарт 1 гарч, Монгол улс аудитын компаниудын чанарт ихээхэн анхаарах болсон. Энэ стандартаар аудитын компаниуд өөрсдийн бүртгэл, аудитын үйл ажиллагаандаа **чанарын хяналтын тогтолцоог** бүрдүүлсэн байх ёстой Чанарын хяналтын тогтолцоо нь аудитын компанийн ажилтан, албан хаагчид, аудиторууд мэргэжлийн стандарт, компанийн чанарын хяналтын дүрэм журмыг мөрдөж байгааг баталгаажуулах цогц үйл ажиллагаа юм.

№	Чанарын хяналтын тогтолцооны элементүүд	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа
1	Аудитын компанийн хүлээх хариуцлага	Гэрээт ажлыг гүйцэтгэхэд хамгийн чухал зүйл нь чанар гэж хүлээн зөвшөөрсөн байгууллагын дотоод соёлыг урамшуулан дэмжсэн бодлого, горим боловсруулна.
2	Ёс зүйн шаардлага	Шударга ёс, бодитой байх, мэргэжлийн ур чадвар хянамгай байдал, нууцыг хадгалах, мэргэжлийн зан төлөв, хараат бус байх
3	Үйлчлүүлэгчтэй тогтоосон харилцаа холбоо ба аудитын гэрээт ажлыг хүлээн зөвшөөрөх, үргэлжлүүлэх	Аудитын компани мэдээллийг цуглуулаад гэрээт ажил, үйлчлүүлэгчтэй тогтоосон харилцаагаа зөвшөөрөх буюу үргэлжлүүлэхээр шийдсэн тохиолдолд асуудлыг хэрхэн шийдвэрлэснээ баримтжуулна.
4	Боловсон хүчний менежмент	Аудитын компани мэргэжлийн стандарт, хууль эрх зүйн шаардлагыг мөрдөж байгаагаа болон гаргасан тайлан нь тухайн нөхцөл байдалд тохирсон гэдгийг үндэслэлтэй баталгаагаар хангахад зориулагдсан бодлого, горимыг тогтооно.
5	Гэрээт ажлын гүйцэтгэл	Мэргэжлийн стандарт, хууль эрх зүйн шаардлага, аудитын компанийн чанарын хяналтын стандартад нийцүүлэн гэрээт ажлыг төлөвлөж, гүйцэтгэх, хянах, шалгах, баримтжуулах, мэдээлэх зэрэг ажлын бүх л үе шатанд гүйцэтгэж байгааг батлах бодлого, горимыг тогтооно.
6	Хяналт (Мониторинг)	Чанарын хяналтын бодлого, горимууд нь тус бүрдээ зүй зохистой, үр дүнтэй ажиллаж, практикт мөрдөгдөх тухай бодлого, горимыг боловсруулна.

Аудитын тухай хуульд зааснаар аудитын үйл ажиллагаанд хуулийг чандлан сахиж, Аудитын олон улсын стандартад заасан арга хэлбэрээр аудитын үйл ажиллагааг явуулна хэмээн заасан. Түүнчлэн аудитын компаниуд олон улсын болон үндэсний стандартад нийцүүлэн “Аудитын үйлчилгээний дотоод стандарт”-ыг баталж тухайн байгууллагад мөрдөж болохыг тусгасан. Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт 2009 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсад аудитын үйл ажиллагаа эрхэлж байгаа компаниудын нийт орлогын хэмжээ, актив хөрөнгийн хэмжээ, өөрийн хөрөнгийн хэмжээ, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, орлогын татвар төлөлт гэсэн үзүүлэлтээр эхний 10 байр эзлүүлсэн. Энэ жагсаалтаар нь компаниудын банк бус санхүүгийн байгууллагад аудит хийсэн судалгааг харахад дараахь байдалтай байна.

№	Компанийн нэр	ББСБ-д аудит хийсэн тоо	Нийт тоонд эзлэх хувь
1	НИММ Аудит ХХК	3	1.6%
2	Тэнцвэр Оргил Аудит ХХК		
3	Далайван Аудит ХХК	1	0.5%
4	Улаанбаатар Аудит Корпораци ХХК	3	1.6%
5	Итгэлт Аудит ХХК	4	2.13%
6	Ситико Аудит ХХК	5	2.66%
7	Онч Аудит ХХК		
8	Ди Эй Би Жи Аудит ХХК	1	0.5%
9	Пантер Мидланд Аудит ХХК	2	1.0%
10	Нийслэл Аудит ХХК	1	0.5%
	Нийт	20	10.6%

Дээрх баримтаас харахад аудитын компани хамгийн ихдээ 5 банк бус санхүүгийн байгууллагад аудит хийсэн байх ба компани бүрийн хувьд үйлчлүүлэгчдийн тоо харилцан адилгүй байна. 2010 оны эхний 10 сарын байдлаар үйл ажиллагаагаа явуулж буй 188 банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг судлаж үзвэл:

№	Үйл ажиллагааны төрөл	Тоо	Нийт тоонд эзлэх хувь
1	Зээл	139	74%
2	Гадаад валютын арилжаа	110	58,5%
3	Итгэлцлийн үйлчилгээ	9	4,8%
4	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	9	4,8%
5	Факторингийн үйлчилгээ	6	3,2%
6	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	6	3,2%
7	Төлбөрийн баталгаа гаргах	5	2,7%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	1%
	Нийт	188	100%

Банк бус санхүүгийн байгууллагын явуулж буй зонхилох үйл ажиллагаагаа нь зээл, гадаад валютын арилжаа байна. 2010 оны эхний хагас жилийн байдлаар Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн тайлангийн нэгтгэлээс харахад:

№	Үзүүлэлт	Нийт дүн	Нийт хөрөнгөнд эзлэх хувь
1	Мөнгөн хөрөнгө	35,949,875.9	31.1%
2	Зээл	67,754,807.0	58.6%
3	Үндсэн хөрөнгө	4,745,687.1	4.1%
4	Бусад	7,089,314.7	6.2%
	Эргэлтийн хөрөнгө	110,793,997.5	95.9%

	Нийт хөрөнгө	115,539,684.7	100.0%
5	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	5,406,108.2	4.7%
6	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	15,431,118.6	13.4%
7	Бусад	8,953,163.9	7.7%
	Нийт өр төлбөр	29,790,390.7	25.8%
9	Хувьцаат капитал	77,179,517.4	66.8%
10	Хуримтлагдсан ашиг/алдагдал	5,954,328.8	5.2%
11	Бусад	2,615,447.8	2.2%
	Эзэмшигчдийн өмч	85,749,294.0	74.2%
	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	115,539,684.7	100.0%

Үүнээс банк бус санхүүгийн байгууллагад аудитын үйлчилгээ явуулахад эзэмшигчийн өмчийн аудит, зээлийн аудит, мөнгөн хөрөнгийн аудит, хуримтлагдсан ашгийн аудит, итгэлцлийн үйлчилгээний аудит, үндсэн хөрөнгийн аудитад анхаарал хандуулан тусгай горим гүйцэтгэх хэрэгтэйг харуулж байна.

1.2 Практик хэрэглээ-Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын горимууд

Бид судалгааны явцад “Далай ван-Аудит” ХХК, Мэдээлэл-Аудит ХХК-иуд дээр очиж банк бус санхүүгийн байгууллагад хийсэн аудитын ажлын баримттай танилцсан.

№	Аудитын компанийн нэр	ББСБ-ын нэр	ББСБ-д аудит хийх дотоод хөтөлбөртэй эсэх	Аудиторын дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлсэн эсэх	Ажлын баримт бүрдүүлэлт
1	Далай ван-Аудит ХХК	Кредит монгол	Үгүй	Тийм	Дунд зэрэг
	Мэдээлэл-Аудит ХХК	АБТС	Үгүй	Тийм	Дунд зэрэг
		Түмэн эрхэс		Тийм	Хангалтгүй
		Баян-Эрч сан		Тийм	Хангалтгүй

Манай аудитын компаниуд нь тусгайлсан банк бус санхүүгийн байгууллагад хийх аудитын хөтөлбөр горимуудыг боловсруулж ажиллаагүйгээс аудитын ажлын баримт нь нийтлэг бизнесийн байгууллага, компаниудад хэрэглэгддэг баримтыг ашигласан бөгөөд банк бус санхүүгийн байгууллагын бүртгэлийн ажил гүйлгээний онцлог, санхүүгийн тайлангийн мэдээлэлд хангалттай сайн эрсдлийг тооцож горимоо гүйцэтгээгүй нийтлэг байдал ажиглагдсан. Материаллаг байдлын болон, уламжлалт эрсдлийг тооцож гаргасан бөгөөд тухайн үйлчлүүлэгчийн бүртгэлийн онцлоготой тохирсон эрсдлийн түвшинг хангалттай сайн үнэлж чадаагүйгээс аудитын горим оновчтой биш байх, илүү

цаг хугацаа алдах, алдааны илрүүлэлт дутмаг байх байдал нийтлэг бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан холбогдох журам, хуулиудад нийцэж байгаа эсэхэд гол анхаарлаа хандуулж шалгаж байгаа ч бусад хууль бус залилан, хувийн үйлчилгээ, хөрөнгийн удирдлагатай холбоотой асуудлуудыг хөндөж тавьсан байдал ажлын баримт дутмаг байлаа. Иймд нягтлан бодох бүртгэл, аудитын мэргэжлийн төрийн болон хувийн байгууллагуудын чадавхийг сайжруулах, төрийн байгууллагуудын мэдээллийн нэгдсэн санг бий болгож, тэдгээр мэдээллийг үйл ажиллагаандаа хамтран ашиглах, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлэх шаардлага өнөөдөр зүй ёсоор тавигдаад байна.

Санхүүгийн тайлангийн аудитын үйл ажиллагааны чанарын хяналтыг сайжруулахын тулд чанарын хяналтын тогтолцооны элементүүд тус бүрийг Аудитын олон улсын стандартад нийцүүлэн хангалттай, зохистой баримт нотолгоог цуглуулан боловсруулах хэрэгтэй.

Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс аудитын чанарын хяналтын тогтолцоог нэвтрүүлэхэд анхаарч, Аудитын олон улсын стандартын талаарх нэмэлт өөрчлөлт, Чанарын хяналтын олон улсын стандартыг компаниудад нэвтрүүлэн ажилллаж байгаа эсэхэд анхаарч улмаар Сангийн яамтай хамтарсан шалгалтыг зохион байгуулан явуулдаг нь тодорхой хэмжээний дэвшилттэй тал юм.

1.3 Олон улсад хэрэглэгдэж байгаа аудитын чанарын хяналт

Бид Сингапур, Малайз, Япон улсын аудитын чанарын хяналтын тогтолцоог судалсан.

Японы мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс аудитад итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээнүүдийг авч ирсэн бөгөөд санхүү болон банкны чиглэлд зориулсан аудитын өвөрмөц горимтой холбоотой асуудлыг хянаж зохицуулах зорилгоор 1996 онд санхүүгийн байгууллагад үйлчлэх Аудитын тусгай хороог байгуулсан байна. IAASB нь Японы бизнесийн нягтлан бодогчдын зөвлөл ба Аудитын стандартын хорооны зарим гишүүдийн саналыг авч өөрчлөлт шинэчлэлтийг хийж байна. Японы санхүүгийн үйлчилгээний агентлаг том хэмжээний аудитын компаниудад чанарын хяналтыг жил бүр явуулж байна. Институтын чанарын хяналтын хорооны тайланг Санхүүгийн үйлчилгээний агентлаг нь авч хэлэлцдэг ба тэд аудитын стандартыг Чанарын хяналтын олон улсын стандарт 1-ийг хамт хэрэглэдэг.

Аудитын аргачлалын гол онцлог ба анхаарах зүйл нь эрсдлийн аргачлал, чанарт анхаарлаа төвлөрүүлэх, аудитын үйл ажиллагааны удирдлага, буруу тайлагнал болон алдааг авч хэлэлцдэг.

Сангийн Яамны зөвлөл болох Бизнесийн нягтлан бодогчдын зөвлөл /ВАС/ нь гол стандартуудыг боловсруулан гаргаж ирсэн бөгөөд Институт нь аудитын стандарт боловсруулах явцад олон улсын чиг хандлагыг нэвтрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн.

Сингапур улсын хувьд 1994-1997 онд аудитын баталгаажуулалтыг сайжруулах зорилгоор аудитын чанарт дүн тавих аргыг хэрэглэсээр иржээ. Ажлын баримтуудыг шалгаад хангалттай, дахин шалгуулах, зөвлөгөө өгөх ба дахин шалгах гэсэн үнэлгээг өгдөг байна. Нягтлан бодох бүртгэл ба корпорацийн зохицуулалтын газар /ACRA/ 2004 онд байгуулагдан аудитын чанарын хяналтыг хариуцдаг байна. ASRA нь нягтлан бодогч аудиторруудыг зохицуулах асуудлаар Засгийн газартаа зөвлөх, аж ахуй нэгж байгууллага аудиторын улсын бүртгэлийг эрхлэх, энэ талаарх мэдээллийг хадгалах, хууль дүрмийн шаардлага, компанийн засаглалын талаарх олон нийтийг хөхүүлэн дэмжих мөн бизнес эрхлэхийн тулд заавал бүртгүүлдэг ба санхүүгийн тайланг хүлээн авдаг байна.

Малайз нь эрт үеэс Английн нягтлан бодох бүртгэл, аудитын загварыг баримталж ирсэн бөгөөд одоо Санхүүгийн тайлангийн олон улсын стандартыг мөрдөж байгаа харьцангуй өндөр хөгжилтэй, мэргэжлийн бүтэц зохион байгуулалт, арга технологийн хувьд жишиг болсон улс юм. Нягтлан бодох бүртгэл, аудитыг зохицуулахад Сангийн яам, MIA, MASB, MISPA байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд Сингапур улстэй төстэй аудитын чанарын хяналтыг хэрэгжүүлдэг байна.

Улс орнуудын санхүүгийн байгууллагад хийсэн аудиторруудын горимуудыг судалж үзэхэд Английн аудитын компанийн банк санхүүгийн байгууллагад хийсэн аудиторын дүгнэлтүүд:

1. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн нийт хөрөнгө, нийт өр төлбөр, эзэмшигчийн өмчийн тайлант үеийн өөрчлөлтүүдийн дүнгүүдийг баталгаажуулах зорилгоор биднийг үзэхэд ийм дүнгүүдээр буурсан, өссөн байна гэж тодорхойлдог байна.
2. Санхүүгийн тайлангийн аудитын зорилго нь гол 3 хүчин зүйлийг авч үздэг.
 - Хууль эрх зүйн баримтууд /Татвар төлөгчийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ гэх мэт
 - Тайлант үед хийгдэж байгаа санхүүгийн тайлан, тоон мэдээллүүд
 - Тайлант үеийн өөрчлөлт гарсан ажил гүйлгээний тайлангууд

Санхүүгийн байгууллагын аудитын хөтөлбөр нь ихэнхдээ банкны хадгаламж авах, зээл авах, зээлдүүлэх, төлбөр тооцоо хийх, арилжаа ба сан хөмрөгийн үйл ажиллагааны чиглэлийн байдаг байна. Шаардлагатай тохиолдолд үнэт цаасны баталгаа гаргадаг, брокер, хөрөнгийн удирдлагын, санхүүгийн үүсмэл хэрэгслийн талаар нэмэлт хөтөлбөрийг боловсруулдаг байна. Мөн бизнесийн байгууллага компаниудаас ялгарсан банкны онцлог бэлэн мөнгөний тогтолцоо, хадгаламж эзэмшигчдийн хадгаламж, мөн өмчлөх бусад хөрөнгө, ихээхэн дүнтэй ажил гүйлгээ тусдаа банкны нягтлан бодох бүртгэлийн зарчимд хир нийцэж байгаа эсэхийг шалгадаг.

Олон улсад ихэвчлэн тусгайлсан зарчмуудад нийцүүлэх зорилгоор банктэй холбоотой тухайн улсын хууль тогтоомжийн шаардлагууд,

зохицуулагч байгууллагын мэдэгдэл, Санхүүгийн тайлагналын олон улсын нийцэлт, тухайн улсын хяналт шалгалтыг тунхаглалуудыг эх сурвалжаа болгодог байна. Улс орон бүрт банкны санхүүгийн байдал, гүйцэтгэлд шинжилгээг хийхэд нийтлэг ашиглагддаг санхүүгийн мэдээлэл, харьцаа, үзүүлэлт нь өөр өөр байна. Банкны санхүүгийн тайлангийн аудитаар активын чанар, хөрвөх чадвар, ашиг, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зах зээлийн эрсдэл, санхүүжилтийн эрсдлийн харьцааг зайлшгүй тооцдог байна.

Хоёр. Судалгааны үр дүн

Аудитын чанарын хяналтыг сайжруулснаар:

- Аудитын олон улсын стандартыг дагаж мөрдөх практик үйл ажиллагаа сайжирч, цаашид аудитын чанарын хяналтын баталгаажуулалт өндөр түвшинд хийгдэнэ.
- Аудитын Чанарын хяналтын олон улсын стандарт 1-ийн дагуу шалгалт хийж, зөвлөгөө өгснөөр аудитын чанарын шаардлагыг хангаж ажиллах, аудитад итгэх итгэлийг нийгмийн хэмжээнд хадгална.
- Аудитын ажлыг баримтжуулах нь ажлын чанарт тавих дотоод хяналтын үр нөлөөг ихэсгэж улмаар илрүүлэлтийг эрсдлийг бууруулахад нэг алхам болно.
- Гүйцэтгэсэн горим, шалгалтын явцад нямбай хөтөлсөн тэмдэглэл, цуглуулсан нотолгоо зэрэг баримтууд нь аудиторын үйл ажиллагаа, гүйцэтгэсэн шалгалтанд үнэлэлт дүгнэлт хийж, тэдгээрийн үнэн зөв, бүрдэл, ашиг тусыг үнэлэх, ингэснээр аудитын явцыг хянах, аливаа алдааг засахад ач холбогдолтой юм.

Аудитын компаниудын хувьд Аудитын олон улсын стандартын дагуу агууллагыг багтаасан банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тусгасан, ойлгомжтой, ашиглахад хялбар, аудитын үйл ажиллагааны өдөр тутмын хэрэглээ болж чадахуйц “Банк бус санхүүгийн байгууллагад хийх аудитын дотоод хөтөлбөр”-ын үлгэрчилсэн загварыг бусад улс орнуудын байдалд тулгуурлан гаргалаа.

ББСБ-д аудит хийх үйлчилгээний дотоод хөтөлбөр

№	Аудитын үе шат	Гүйцэтгэх үйл ажиллагаа	Үйл ажиллагааны зорилго	Хэрэглэгдэх ажлын баримт
1	Аудитын төлөвлөлтийн үе шат			
1.1	Аудитад бэлтгэл үе	Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн тайланд хийх шалгалтын зорилгоо тодорхойлох	Үйлчлүүлэгчийн хүлээн зөвшөөрөх, эс зөвшөөрөх Үйлчлүүлэгчийн гадаад болон дотоод нөхцөл байдлыг судлан шинжлэх Аудиторууд хараат бус	Аудитын гэрээт ажлыг шинээр хүлээж авах Шаардлагатай материалууд ба мэдээллүүдийн жагсаалт Сонирхлын зөрчилгүй

			ажиллах мэдээлэл	талаар	тухай мэдэгдэл
		Үйлчлүүлэгчид ажлын захидал хүргүүлэх	Санхүүгийн үнэн зөв талаарх мэдэгдэл өгөх	тайланг гаргасан	Удирдлагын хариуцлагын захидал
			Үйлчлүүлэгчийн хүрээг тогтоох	цар	Аудитын ажлын цагийн төсөв
1.2	Үйлчлүүлэгчийн талаар ерөнхий ойлголт олж авах	Материаллагын түвшинг тодорхойлох	Тухайн банк санхүүгийн байгууллагын материаллагын түвшинг тодорхойлох	бус	- Материаллаг дүн бүхий эрсдлийг илрүүлэх - Зээлийн эрсдэл
		Аудитын эрсдлийг үнэлэх	Уламжлалт хяналтын илрүүлэлтийн эрсдлийг тодорхойлох	эрсдэл, эрсдэл,	-Валютын эрсдэл - Хүүгийн түвшний эрсдэл - Хөрөнгийн эрсдэл -Нөлөөллийн эрсдэл -Гүйцэтгэлийн эрсдэл
		Дотоод хяналтын системийг судлаж , үнэлгээ өгөх	Удирдлагын нягтлан бодох дотоод систем, удирдлага, хяналтын чиг үүргийн талаар ойлголт авах	бүтэц, бүртгэл, хяналтын эрсдэлийн дотоод	-Хуулийн эрсдэл -Нэр хүндийн эрсдэл
1.3	Санхүүгийн тайланд урьдчилсан тойм судалгаа хийх	Санхүүгийн тайланд бүтэц бүрэлдэхүүн, хэлбэлзэл өөрчлөлтийн шинжилгээ хийх, харьцааны шинжилгээ хийх	Байгууллагын байж магадлалтай гүйлгээ болон, бус тодорхойлох	алдаа болох ажил хэвийн зүйлсийг	-Санхүүгийн тайлангийн шинжилгээ ба дүгнэлт Бүх эрсдүүлийг үнэлж нэгтгээд хамгийн их эрсдэлд өртөмтгий хүчин зүйлсээр тусгайлсан горимуудыг гүйцэтгэх
1.4	Аудитын төлөвлөлтийн ажлыг үнэлэх объект дээрх шалгалтыг зохион байгуулах	Төлөвлөлтийн дагуу аудитын гүйцэтгэлийн шатруу шилжих	Үйлчлүүлэгчийн гадаад болон дотоод байдлын судалгаа авч төлөвлөлтөөс хамаарч аудитын горимын хүрээг тогтооно.	цар	-Материаллаг байдлыг тодорхойлох маягт - Дотоод хяналтын хуудас -
1.5	Аудитын хөтөлбөр боловсруулах	Данс бүрээр аудитор аудитын хөтөлбөр боловсруулах	Аудитын ажиллагааг гүйцэтгэх	үйл чанартай	Банкны санхүүгийн тайлангийн аудитаар активын чанар, хөрвөх чадвар, ашиг, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зах зээлийн эрсдэл, санхүүжилтийн

					эрсдийн харьцааг зайлшгүй тооцож хөтөлбөрийг боловсруулах
2	Аудитын гүйцэтгэлийн үе шат				
2.1	Боловсруулсан аудитын хөтөлбөр дагуу шалгалт явуулах	Аудитын нотолгоог цуглуулах	Аудитын горимууд болох -Хөрөнгийн ба тооцоолол - Ажиглалт хийх - Асуулга авах -Тулган баталгаажуулах - Шалгалт хийх - Шинжилгээ хийх - Давтан гүйцэтгэх	горимууд тооллого	-Мөнгөн хөрөнгийн аудитын хөтөлбөр -Зээлийн аудитын хөтөлбөр -Авлагын аудитын хөтөлбөр -Итгэлцлийн аудитын хөтөлбөр -Үндсэн хөрөнгийн аудитын хөтөлбөр - Өр төлбөрийн аудитын хөтөлбөр -Эзэмшигчийн өмчийн аудитын хөтөлбөр -Орлогын болон зардлын аудит хөтөлбөр
3	Аудитын дүгнэлтийн үе шат				
3.1	Гүйцэтгэл ийг үнэлэх	Аудит хийсэн аудиторын /дүгнэлт/-г үйлчлүүлэгч байгууллагын удирдлагад хүлээлгэн өгөх	хийсэн тайлан - Хийж гүйцэтгэсэн горимуудаа нягтлан шалгах - Аудитын зөрүүнүүдийг хэлэлцэж дүгнэлтийг өгөх	гүйцэтгэсэн дахин шалгах	-Аудитын зөрүүнүүдийн үнэлгээний маягт -Аудитын зөрүүнүүдийн нэгтгэл - Аудитын тайлангийн шалгах хуудас - Ажилтны үнэлгээ

2. Аудитор Аудитын олон улсын стандарт 210-т заасан аудитын ажлын захидлын ерөнхий нөхцлүүдээс гадна банк бус санхүүгийн байгууллагатай холбоотой хууль тогтоомжинд заасан аливаа шаардлагууд, Санхүүгийн зохицуулах хорооны заавар журмуудын холбогдох зарчмуудын шаардлагыг харгалзан үзнэ. Бусад улс орны туршлагаас харахад санхүүгийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын ерөнхий төлөвлөгөө боловсруулахдаа аудитор нь:

- Гүйцэтгэж буй ажил гүйлгээ, түүний баримтжуулалтын нарийн түвэгтэй байдал,
- Аливаа гол үйл ажиллагааг үйлчилгээний байгууллагаар гүйцэтгүүлдэг ажлын цар хэмжээ,
- Болзошгүй өр төлбөр ба балансын гадуурхи зүйлс,
- Зохицуулалтын асуудлууд,

- Ашиглаж буй мэдээллийн технологийн болон бусад тогтолцооны цар хэмжээ,
- Уламжлалт болон хяналтын эрсдлийн хүлээгдэж буй үнэлгээ,
- Материаллаг байдлын үнэлгээ,
- Удирдлагын тайлбар мэдүүлэг,
- Бусад аудиторын оролцоо,
- Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны газар зүйн тархалт, аудитын багуудын хоорондын зохицуулалт,
- Хэлхээ холбоотой талуудын хооронд ажил гүйлгээ хийгдсэн эсэх, ба
- Өөдрөг үйл ажиллагааны холбогдолтой асуудлуудыг авч үзэх шаардлагатай юм байна.

Олон Улсад банк санхүүгийн байгууллагад аудит хийх тусгайлсан стандартыг өөрийн оронд нийцүүлэн боловсруулан гаргасан бөгөөд стандартын хэрэгжилт, үйл явцыг хянаж зохицуулдаг тогтолцоо нь хуулиар тогтоогдсон байдаг байна. Мөн банкны аудит нь санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэлийн гэсэн чиглэлүүдтэй байх бөгөөд Санхүүгийн тайлангийн аудитын хөтөлбөрүүд нь зайлшгүй тооцогдох харьцааны үзүүлэлт болон эрсдлүүдийн үнэлгээгээр шинжилгээ хийж, хөтөлбөр горимуудыг тусгайд нь боловсруулагддаг.

Санал дүгнэлт.

- Олон улсын жишигт нийцүүлэн нягтлан бодох бүртгэл, аудитын тогтолцоог өөрчлөн зохион байгуулах шаардлага тулгарч байна. Энэ хөгжингүй улс орнуудын туршлага судлахад Сангийн яамны зөвлөл болох нягтлан бодох бүртгэлийн аудитын зохицуулах хороо нь нягтлан бодогчид, аудиторуудын чадавхийг нэмэгдүүлэх, хянах, зохицуулах ажилд үнэлэлт дүгнэлт өгөх гэх мэт чиг үүргийг хуулиар тогтоосон байдаг.
- Аудитын компаниудад чанарын хяналт тавих болон Аудитын олон улсын стандартыг өөрийн оронд нийцүүлэн боловсруулж баталж мөрдүүлэх ажлын чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яаманд хуулиар хэм хэмжээг нь тодорхойлуулах хэрэгтэй. Япон улсын туршлагаас Сангийн яам нь бодлого зохицуулалтын үүрэг гүйцэтгэж Аудитын олон улсын стандартын өөрчлөлт шинэчлэлтийг боловсруулан баталж гаргадаг бөгөөд Институт нь гүйцэтгэлийг хангах ажлыг зохион байгуулж, Санхүүгийн үйлчилгээний агентлаг /Санхүүгийн зохицуулах хороо/ томоохон аудитын компаниудад Чанарын хяналтын олон улсын стандарт, Аудитын олон улсын стандартын талаарх хэрэгжилт, шалгалтыг жил бүр зохион байгуулж, шалгалтын үр дүнг олон нийтэд зарладаг нээлттэй тогтолцоотой байдгаараа онцлог юм.
- Санхүүгийн зохицуулах хороо, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институттэй хамтран Бичил санхүүгийн байгууллагуудад

аудит хийж байгаа байгууллагуудад зэрэглэл тогтоох, /аудитын компанийн менежментийн байдал, аудиторын тоо, туршлага дотоод стандартын мөрдөлт, ажлын баримт бүрдүүлэлт, баталгаажуулалтын түвшин, үйлчилгээний цар хүрээ, материаллаг санхүүгийн нөөцийн чадварийг/ үнэлж дүгнэлт өгөх

- Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт нэвтэрсэн улс орнуудын нэвтэрсэн улс орнуудын банк бус санхүүгийн байгууллагын болон бичил санхүүгийн аудитын туршлагыг судлан нэвтрүүлэхийн тулд өөрийн улсын онцлогот тохирсон, банк бус санхүүгийн байгууллагын баталж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд, Санхүүгийн зохицуулах хороо нь Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институттэй хамтран улсын хэмжээнд банк бус санхүүгийн байгууллагын аудит хийж байгаа байгууллагуудад “Тусгайлсан бичил санхүү болон банк бус санхүүгийн байгууллагад хийх аудитын хөтөлбөр” баталж мөрдүүлж ажиллах
- 2009 оны эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хороонд санхүүгийн тайлангаа ирүүлсэн 167 банк бус санхүүгийн байгууллагаас аудит хийлгэсэн 102, тухайн онд шинээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан 12, үйл ажиллагаа явуулаагүй 3, аудитын тайлангаа ирүүлээгүй 50, нийт 65 (40%) нь санхүүгийн тайландаа аудит хийлгээгүй, байгаагаас үзэхэд Аудитын тухай хууль болон банк бус санхүүгийн байгууллагын тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн байна. Иймд банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн тайланг олон нийтэд мэдээлэхийн ач холбогдлыг нэмэгдүүлэх, санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах механизмыг Санхүүгийн зохицуулах хороо хангах
- Аудитын байгууллагууд нь үйл ажиллагаандаа мөрддөг нэг хууль дүрэмтэй, нэг стандарттай боловч гүйцэтгэж байгаа ажлын цар хүрээ, чанар, үйлчилгээний үнэ тариф ихээхэн ялгаатай байгаа нь аудитын үйл ажиллагааны чанар харилцан адилгүй байгааг харуулж байна. Үүний тогтолцоог өөрчилж, аудитын чанарын хяналтын горимуудад нийцсэн аудитын төлөвлөгөө хөтөлбөр горимуудын батлагдсан стандарт үнэ, үнэлгээг СЯ-наас тогтоож мөрдүүлэх
- Мөн дотоодын аудитын байгууллагуудын менежмент, эрх зүйн хүрээ, үйл ажиллагаа, туршлага, мэдээллийн сан дутмаг байдал харагдаж байгаа ч цаашид арга хандлагыг тогтоож, хөгжүүлэхэд Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Сангийн яам, Үндэсний аудитын газар, Санхүүгийн зохицуулах хороо байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, компаниудын цар хүрээг нь өргөжүүлэх шаардлага тулгарч байна.
- Санхүүгийн зохицуулах хорооны бичил санхүүгийн газрын банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж,

удирдамжаар хангаж ажилладагч тэдгээр байгууллагуудын аудит хийж буй компанийн талаарх нэгдсэн судалгааг тогтмол гаргаж байх, мэдээллийн нэгдсэн сантай болох шаардлагатай байна.

Ном зүй.

1. Аудитын тухай Монгол улсын хууль. /7-р зүйл/
2. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай Монгол улсын хууль /7-р зүйл/
3. Банкны тухай Монгол улсын хууль
4. “Аудитын үүсэл, хөгжил, тулгамдсан асуудал-2010” эрдэм шинжилгээний бага хурал / 30-31 хуудас/
5. О.Лхагвасүрэн, Л.Энх-Амгалан “Аудит” 2004 он
6. Н.Агваан “Аудит” 2002 он
7. “Аудит баталгаажуулалтын ёс суртахууны тунхаглалуудын гарын авлага” II хэвлэл, 2005 он
8. УАГ “Санхүүгийн тайланд аудит хийх түр журам” 2004
9. Нягтлан бодох бүртгэл хөгжүүлэх сан “Дотоод хяналт” 2008 он 154 тал
10. ММНБИ “АОУС-ын нэмэлт өөрчлөлт” 2007 он
11. Ш. Эрдэнэцэцэг “Банк, санхүүгийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэл” 2008 он
12. ММНБИ “СТОУС-ын хэрэглээний тайлбар 2009 он
13. ММНБИ “ Япон улсын санхүү, бүртгэл аудитын туршлага 2006 он /10-р тал/
14. ММНБИ “Сингапур Малайз улсад НББ, аудитын туршлага судалсан байдал” 2005 он 53 тал
15. <http://www.monicspa.mn/>
16. <http://www.frc.mn/>
17. www.mof.pmis.gov.mn
18. www.sanhuu.mn
19. www.nyabo.mn
20. www.ifac.org
21. www.capa.com.my
22. www.icab-bd.com
23. www.aicpa.org
24. www.iasb.org.uk